

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/98/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 51-260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Энхжаргал Утас: 51-261628 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn Аудитор: Ж.Мөнхбилгүүн Утас: 51-261628 Цахим хаяг: munkhbilguunj@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	23
4.5.1 Завсрын аудитын талаар	23
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	23
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	24
5.1 Төлбөрийн акт	24
5.2 Албан шаардлага	25
5.3 Сахилгын шийтгэл	28
5.3 Зөвлөмж	28
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	31

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АНУ	Америкийн нэгдсэн улс
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
БХС	Батлан хамгаалахын сайд
ЗТС	Зам, тээврийн сайд
ЗТЯ	Зам, тээврийн яам
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ИНҮТ	Иргэний нисэхийн үндэсний төв
МУЕС	Монгол Улсын Ерөнхий Сайд
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХШҮДАА	Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын алба
ХШҮДАГ	Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 061371

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт 2,270,396.8 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.4, 16 дугаар зүйлийн 16.5, 22 дугаар зүйлийн 22.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, тохиолдсон байх, ангилал, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Тухайлбал:

- Тайлант онд 433,091.5 мянган төгрөгийн авлага, 933,376.5 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 139,558.4 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 15,124.1 мянган төгрөгийн орон сууц нь бусад байгууллага, иргэний нэр дээр гэрчилгээтэй, 449,457.4 мянган төгрөгийн ашиглалтгүй байгаа 7 ширхэг байшинг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй;

- Албан томилолтын төсөв, гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаагүй, тушаал шийдвэр, удирдамжгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, гадаад болон дотоод албан томилолтын нийт 220,317.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн;
- Хөрөнгийн барьцаа дансны үлдэгдлээс 65,254.2 мянган төгрөгийн олон жилийн насжилттай барьцааг шийдвэрлээгүй;
- Цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг буруу тооцож нийт 11,177.7 мянган төгрөгийг илүү олгосон.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Иргэний нисэхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга) 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж, Засгийн газрын 2024 оны 189, 193 дугаар тогтоолоор Иргэний нисэхийн ерөнхий газар нь Засгийн газрын тохируулагч агентлагийн үйл ажиллагааг, “Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК агаарын навигаци, нисэх буудал, харуул хамгаалалтын үйлчилгээг эрхлэн гүйцэтгэхээр болж байгууллагын зохион байгуулалтын бүтэц, чиг үүрэгт өөрчлөлт орсон байна.

Зам, тээврийн сайдын 2025 оны А/256 дугаар тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн 6 газар, 7 хэлтэс, 96 орон тоотойгоор баталсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант оны нийт орлогын 99.7 хувь 299,403,928.2 мянган төгрөгийг агаарын навигацийн орлого, 0.2 хувь 651,516.3 мянган төгрөгийг бусад орлого, 0.1 хувь 349,460.5 мянган төгрөгийг нисэхийн аюулгүй ажиллагааны үйлчилгээний орлого эзэлж байна. Тайлант онд навигацийн орлогоос нийт 80,000.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Засгийн газрын 2024 оны 193 дугаар “Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай” тогтоолоор Иргэний нисэхийн үндэсний төв нь Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болж, агаарын навигаци, нисэх буудал, нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой Иргэний нисэхийн ерөнхий газрын балансаас “Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ийн баланст шилжүүлэхийг даалгасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 438 дугаар тогтоолоор 849,011,046.2 мянган төгрөгийн балансын үнэ бүхий барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг шилжүүлсэн байна.

Бусад асуудал

Зам, тээврийн сайдын 2024 оны А/89 дүгээр тушаал, Зам, тээврийн сайд, Батлан хамгаалахын сайдын хамтарсан 2025 оны А/07-07 дугаар тушаалаар “Монгол улсад нисэх хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ой”-г тэмдэглэн өнгөрүүлсэн байна.

Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас 2026 онд Аюулгүй ажиллагаанд тавих хяналтын нэгдсэн аудитын хөтөлбөрийн хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газарт аудит хийхээр төлөвлөсөн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Б.А.В.* Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	101,900,208,648.54	106,725,342,317.35
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	61,448,843,000.52	63,674,582,778.58
312	Банканд байгаа бэлэн мөнгө	61,448,843,000.52	63,674,582,778.58
3121	Төгрөг	11,131,505,497.87	26,537,745,735.16
3122	Гадаад валют	50,317,337,502.65	37,136,837,043.42
33	АВЛАГА	40,322,236,792.59	37,072,314,037.75
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,402,237.22	15,324,987.83
33401	Дансны авлага	18,784,488,640.74	29,044,274,040.57
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	6,863,649,967.02	7,068,660,610.75
335	Бусад авлага	14,670,695,947.61	944,054,398.60
3351	Байгууллагаас авах авлага	14,586,803,734.28	860,162,185.28
3352	Хувь хүмүүсээс авах авлага	83,892,213.33	83,892,213.32
34	УРЬДЧИЛГАА	4,350,835.00	658,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	4,350,835.00	658,000.00
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	4,350,835.00	658,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	124,778,020.43	5,977,787,501.02
354	Хангамжийн материал	124,778,020.43	5,977,787,501.02
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,076,037,531,371.00	909,911,002,148.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,076,037,531,371.00	909,911,002,148.86
391	Газар	104,167,279,369.40	30,292,864,457.60
392	Биет хөрөнгө	969,585,072,576.18	877,427,945,163.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	947,079,608,305.96	912,739,614,197.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	(127,505,775,966.54)	(155,368,138,759.59)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	59,119,533,400.00	55,766,425,558.93
39204	Хуримтлагдсан элэгдэл	(20,704,787,300.57)	(24,590,454,381.39)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	147,271,449,228.64	133,928,289,746.54
39206	Хуримтлагдсан элэгдэл	(56,447,987,639.14)	(64,549,414,489.23)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,472,660,693.01	1,448,366,375.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(648,490,239.00)	(733,559,593.69)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	19,948,862,093.82	18,786,816,509.20
393	Биет бус хөрөнгө	381,882,512.84	286,895,615.30
39301	Программ хангамж	580,635,782.49	580,635,782.49
39302	Хуримтлагдсан элэгдэл	(198,753,269.65)	(293,740,167.19)
394	Бусад хөрөнгө	1,903,296,912.58	1,903,296,912.58
39403	Хойшлогдсон татварын хөрөнгө	1,903,296,912.58	1,903,296,912.58
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,177,937,740,019.54	1,016,636,344,466.21
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	22,602,416,576.51	21,608,194,434.34
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,621,103,324.07	18,626,881,181.90
413	Өглөг	4,346,187,363.14	3,850,371,857.28
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	1,800,524,406.52	1,520,336,275.00
4136	Бусад өглөг	2,545,662,956.62	2,330,035,582.28
414	Урьдчилж орсон орлого	15,274,915,960.93	14,776,509,324.62
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,981,313,252.44	2,981,313,252.44
422	Урт хугацаат зээл	2,981,313,252.44	2,981,313,252.44
4222	Гадаад валют	2,981,313,252.44	2,981,313,252.44
42229	Хойшлогдсон татварын өр	2,981,313,252.44	2,981,313,252.44
51	Засгийн газрын хувь оролцоо	1,155,335,323,443.03	995,028,150,031.87
51101	Засгийн газрын хувь оролцоо	1,505,138,364,445.13	1,428,290,180,430.75
51102	Дахин үнэлгээний нэмэгдэл	299,483,032.84	299,483,032.84
51103	Бусад цэвэр хөрөнгө/өмч	-	1,814,450,348.17

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51200	Хуримтлагдсан үр дүн	(350,102,524,034.94)	(435,375,963,779.89)
51210	Өмнөх үеийн үр дүн	(135,043,068,263.97)	(403,517,414,501.64)
51220	Тайлант үеийн үр дүн	(75,567,028,012.1)	(31,858,549,278.25)
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,155,335,323,443.03	995,028,150,031.87
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,177,937,740,019.54	1,016,636,344,466.21

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	233,230,666,145.63	304,045,574,092.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	229,319,883,445.63	300,404,904,960.37
120	Нийтлэг татварын бус орлого	229,319,883,445.63	300,404,904,960.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	227,970,279,692.24	299,753,388,651.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	227,970,279,692.24	299,403,928,196.13
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	349,460,455.37
120009	Бусад орлого	1,349,603,753.39	651,516,308.87
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,910,782,700.00	3,640,669,132.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,910,782,700.00	3,640,669,132.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,910,782,700.00	3,640,669,132.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	159,118,203,681.97	346,286,538,766.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	159,118,203,681.97	346,286,538,766.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	75,403,645,805.90	265,610,071,124.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,694,519,780.42	8,608,797,762.83
210101	Цалин	2,981,400,966.42	4,142,856,973.93
210102	Цалингийн тусгай нэмэгдлүүд	2,713,118,814.00	4,465,940,788.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	704,211,043.32	990,928,381.93
210201	Тэтгэвэр болон тэтгэмжийн даатгал	704,211,043.32	836,177,917.94
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	-	154,750,463.99
2103	Тогтмол зардал	20,622,409.77	110,885,712.05
210301	Гэрэл, цахилгаан	20,622,409.77	31,626,413.10
210302	Түлш, халаалт	-	69,128,708.78
210303	Цэвэр, бохир ус	-	10,130,590.17
2104	Бусад бараа үйлчилгээний зардал	68,984,292,572.39	255,899,459,267.87
210401	Бичиг хэрэг	71,819,244.93	31,422,266.47
210402	Тээвэр, шатахуун	-	68,864,828.15
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	56,536,938.31	12,696,663.69
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,674,340.21	-
210701	Гадаад албан томилолт	760,648,396.53	847,053,307.57
210702	Дотоод албан томилолт	71,215,271.00	61,897,411.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,004,129,634.35	352,933,480.45
	Жижиг эд хогшил худалдан авах зардал	-	48,503,184.52
210503	Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	-	39,408,183.48
210604	Урсгал засвар	13,601,172.49	78,914,663.19
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	45,281,456.40
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	34,256,647.61	34,596,716.85
118001	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	7,062,085.38
	Элэгдлийн зардал	64,882,048,944.46	54,302,595,374.10

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	Бусад зардал	84,361,982.50	199,968,229,645.92
212	ТАТААС	294,455,833.64	-
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	294,455,833.64	-
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	294,455,833.64	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,420,102,042.43	80,676,467,641.59
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	80,000,000,000.00	80,000,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	80,000,000,000.00	80,000,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,420,102,042.43	676,467,641.59
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	53,036,465.22	449,266,909.59
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	367,065,577.21	227,200,732.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	74,112,462,463.66	(42,240,964,673.90)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	5,669,321,192.11	18,808,268,099.90
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	5,669,321,192.11	11,634,529,522.54
145007	Хүлээн авсан хүүний орлого	-	972,453,894.51
145008	Бусад олз	-	6,201,284,682.85
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	135,580,424,451.81	8,425,852,704.25
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз		8,425,852,704.25
225005	Бусад гарз	135,580,424,451.81	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(129,911,103,259.70)	10,382,415,395.65
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(55,798,640,796.04)	(31,858,549,278.25)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	235,731,190,420.60	611,091,211,802.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	231,820,407,720.60	607,450,543,570.76
120	Нийтлэг татварын бус орлого	231,820,407,720.60	607,450,543,570.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	231,820,407,720.60	290,618,922,940.54
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	231,820,407,720.60	290,272,627,933.70
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	346,295,006.84
120009	Бусад орлого	-	316,094,619,976.22
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	737,000,654.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,910,782,700.00	3,640,668,232.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,910,782,700.00	3,640,668,232.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,910,782,700.00	3,640,668,232.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	218,617,250,453.49	609,484,882,854.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	218,617,250,453.49	609,484,882,854.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	138,539,540,356.31	528,635,702,895.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,551,641,899.88	8,368,258,049.40
210101	Үндсэн цалин	5,232,802,406.88	6,343,034,233.53
210102	Нэмэгдэл		524,055,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	318,839,493.00	735,686,400.00
210104	Урамшуулал	-	14,824,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	750,657,715.87

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,045,589,992.56	1,018,321,363.41
210201	Тэтгэврийн даатгал	-	709,938,232.17
210202	Тэтгэмжийн даатгал	-	74,698,749.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	37,349,224.87
210204	Ажилгүйдлийн даатгал	-	37,349,224.87
210205	Эрүүл мэндийн даатгал	-	158,985,931.71
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,045,589,992.56	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,134,026.40	121,864,502.05
210301	Гэрэл, цахилгаан	22,720,650.75	34,786,441.99
210302	Түлш, халаалт	29,297,759.31	75,934,410.87
210303	Цэвэр, бохир ус	17,397,072.00	11,143,649.19
210305	Ашиглалтын зардалд төлсөн	13,718,544.34	-
2104	Хангамж, бараа материалын зардал	198,345,096.87	236,503,477.91
210401	Бичиг хэрэг	25,336,400.00	7,971,900.00
210402	Тээвэр, шатахуун	159,840,210.50	212,105,815.57
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,035,877.42	13,713,362.34
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,132,608.95	2,712,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,082,100.00	117,413,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,586,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,984,700.00	6,273,600.00
210604	Урсгал засвар	2,511,400.00	111,139,500.00
2107	Томилолт, зочны зардал	904,474,200.00	1,032,671,879.40
210701	Гадаад албан томилолт	865,044,200.00	975,462,879.40
210702	Дотоод албан томилолт	39,430,000.00	57,209,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	517,324,139,226.64
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	101,923,934.97
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	329,820,857.75
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	199,395,024.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	8,818,972.08
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	900,000.00
210816	Татварын байгууллагад төлсөн	-	7,278,053,673.60
210818	Бусад мөнгөн зарлага	-	509,290,619,964.24
210819	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	114,606,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	130,727,273,040.60	416,531,296.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	128,484,383,146.60	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,242,889,894.00	416,531,296.77
211	ХҮҮ	77,710,097.18	-
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	77,710,097.18	-
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	77,710,097.18	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,000,000,000.00	80,849,179,958.63
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	80,000,000,000.00	80,000,000,000.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	80,000,000,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	677,043,074.57
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	421,095,271.40
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	227,200,732.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	28,747,071.17
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	172,136,884.06
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	172,136,884.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	17,113,939,967.11	1,606,328,948.55

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	785,000,941.92	972,453,894.51
140007	Хүлээн авсан хүүний орлого	785,000,941.92	972,453,894.51
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,951,149,277.54	353,043,065.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,951,149,277.54	353,043,065.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,951,149,277.54	353,043,065.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	8,951,149,277.54	353,043,065.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(8,166,148,335.62)	619,410,829.51
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	8,947,791,631.49	2,225,739,778.06
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	52,501,051,370.65	61,448,843,000.52
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	61,448,843,000.52	63,674,582,778.58

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	1,505,138,364,445.13	299,483,032.84	-350,102,524,034.90	-	1,155,335,323,443.07
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,505,138,364,445.13	299,483,032.84	-350,102,524,034.90	-	1,155,335,323,443.07
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
2024 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	1,505,138,364,445.13	299,483,032.84	-350,102,524,034.90	-	1,155,335,323,443.07
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,505,138,364,445.13	299,483,032.84	-350,102,524,034.90	-	1,155,335,323,443.07
Өмчид гарсан өөрчлөлт	-76,848,184,014.38	-	-53,414,890,466.73	1,814,450,348.16	-128,448,624,132.95
Тайлант үеийн үр дүн	-	-	-31,858,549,278.25	-	-31,858,549,278.25
2025 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	1,428,290,180,430.75	299,483,032.84	-435,375,963,779.88	1,814,450,348.16	995,028,150,031.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Данс код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,057,255,600.00	3,468,532,247.94	588,723,352.06	85.5
12	Татварын бус орлого	4,057,255,600.00	3,468,532,247.94	588,723,352.06	85.5
122	Нийтлэг татварын бус орлого	4,057,255,600.00	3,468,532,247.94	588,723,352.06	85.5
122005	Төсвөөс санхүүжих	4,057,255,600.00	3,468,532,247.94	588,723,352.06	85.5
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,057,255,600.00	3,468,532,247.94	588,723,352.06	85.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,057,255,600.00	3,468,532,247.94	588,723,352.06	85.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,298,862,500.00	3,241,331,515.94	57,530,984.06	98.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,797,280,300.00	2,792,496,500.00	4,783,800.00	99.8
210101	Үндсэн цалин	2,128,625,200.00	2,128,625,200.00	-	100.0
210102	Нэмэгдэл	524,055,200.00	524,055,200.00	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	124,991,600.00	124,991,600.00	-	100.0
210104	Урамшуулал	19,608,300.00	14,824,500.00	4,783,800.00	75.6
210105	Гэрээт ажлын хөлс	806,047,000.00	750,657,715.87	55,389,284.13	93.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	349,659,900.00	349,659,900.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	237,768,800.00	237,768,800.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	27,972,800.00	27,972,800.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,986,400.00	13,986,400.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	13,986,400.00	13,986,400.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	55,945,500.00	55,945,500.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,106,600.00	75,569,611.12	12,536,988.88	85.8
210301	Гэрэл, цахилгаан	28,628,600.00	26,443,923.34	2,184,676.66	92.4
210302	Түлш, халаалт	38,837,700.00	38,268,841.99	568,858.01	98.5
210303	Цэвэр, бохир ус	20,640,300.00	10,856,845.79	9,783,454.21	52.6
2104	Хангамж, бараа материалын зардал	30,392,700.00	14,438,464.82	15,954,235.18	47.5
210401	Бичиг хэрэг	7,971,900.00	5,906,490.00	2,065,410.00	74.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,936,000.00	5,819,574.82	12,116,425.18	32.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,484,800.00	2,712,400.00	1,772,400.00	60.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,523,600.00	2,186,400.00	6,337,200.00	25.7
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,273,600.00	-	6,273,600.00	-
210604	Урсгал засвар	2,250,000.00	2,186,400.00	63,600.00	97.2
2107	Томилолт, зочны зардал	4,690,000.00	4,690,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	4,690,000.00	4,690,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,209,400.00	2,290,640.00	17,918,760.00	11.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,391,600.00	1,390,640.00	960.00	99.9
210803	Даатгалын үйлчилгээ	4,479,400.00	-	4,479,400.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,791,800.00	-	1,791,800.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	895,900.00	-	895,900.00	-

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,958,900.00	-	8,958,900.00	76.7
210807	Газрын төлбөр	1,791,800.00	-	1,791,800.00	0.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	900,000.00	900,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	758,393,100.00	227,200,732.00	531,192,368.00	30.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	179,267,400.00	-	179,267,400.00	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	179,267,400.00	-	179,267,400.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	579,125,700.00	227,200,732.00	351,924,968.00	39.2
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	579,125,700.00	227,200,732.00	351,924,968.00	92.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	758,393,100.00	227,200,732.00	531,192,368.00	39.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	61,448,843,000.52	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	63,674,582,778.58	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	96	96	-	100.0
620001	Удирдах ажилтан	2	2	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	94	94	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

ИНЕГ нь иргэний нисэхийг хөгжүүлэх талаар төрөөс баримталж байгаа бодлого, хөтөлбөр, иргэний нисэхийн тухай хууль тогтоомж, Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын стандарт, зөвлөмжийг хэрэгжүүлэх асуудлыг эрхэлсэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг юм. Иргэний нисэхийн ерөнхий газар нь Монгол Улсын олон улсын иргэний нисэхийн гэрээ, конвенцоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд үйл ажиллагаагаа иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангуулах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Тайлант оныг “Иргэний нисэхийн тогтолцоог төгөлдөршүүлэх жил болгон зарлаж, “Агаарын тээврийн үйлчилгээг нэмэгдүүлэх” зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Олон улсын нислэг үйлдэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх;
- Эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох;
- Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын стандарт, шаардлагад нийцүүлэн монгол улсын агаарын навигацийн үйлчилгээний аюулгүй, үр ашигтай, хүртээмжтэй байдлыг бодлого, зохицуулалтаар хангах;
- Агаарын тээврийн салбарын хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээ авах, нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх, бодлого, зохицуулалтаар хангах;
- Олон улсын туршлага, чиг хандлагатай уялдуулан нисэх буудлын үйл ажиллагааны бодлогын санал боловсруулах, бодлогын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх;
- Иргэний нисэхийн салбарын аюулгүй ажиллагааны зохицуулалтыг хийх;
- Иргэний нисэхийн салбарт зохицуулалтыг үнэмлэхжүүлэлт, гэрчилгээжүүлэлтээр хийх;
- Иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт тавих;
- Осол зөрчил давтагдахаас урьдчилан сэргийлэх;
- Иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын мэдээллийн ил тод байдлыг хангах;
- Олон улсын иргэний нисэхийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах;
- Салбарын хууль тогтоомж, дүрэм журмыг шинэчлэхэд болон хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, удирдлагаар хангах;
- Үр ашиггүй зардлыг бууруулж, батлагдсан төсвөө хэмнэх;
- Бодлого, хөтөлбөр, төсөл, хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлэх;
- ИНЕГ-ын үйл ажиллагаанд дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах;
- Иргэний нисэхийн аюулгүй байдлыг сайжруулах;
- Иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангуулах, өгөгдлийн сангийн бүртгэл хөтлөх, хяналт тавих.

Зам, тээврийн сайдын 2025 оны А/256 дугаар тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн 6 газар, 7 хэлтэс, 96 орон тоотой байхаар баталсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Иргэний нисэхийн ерөнхий газар нь үйл ажиллагаандаа Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенц, түүний хавсралтууд, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль, Иргэний тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Улсын нисэхийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгавар

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ИНЕГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн дүгнэлт, зөвлөмж, Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотой байгууллагын “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг ИНЕГ-ын даргын 2025 оны А/259 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

ИНЕГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 161,301,395.6 мянган төгрөгөөр 13.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	61,448,843.0	63,674,582.8	2,225,739.8
Авлага	40,322,236.8	37,072,314.0	(3,249,922.8)

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Урьдчилгаа	4,350.8	658.0	(3,692.8)
Бараа материал	124,778.0	5,977,787.5	5,853,009.5
Үндсэн хөрөнгө	1,076,037,531.4	909,911,002.1	(166,126,529.2)
Нийт хөрөнгө	1,177,937,740.0	1,016,636,344.5	(161,301,395.6)
Өр төлбөр	22,602,416.6	21,608,194.4	(994,222.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,155,335,323.4	995,028,150.0	(160,307,173.4)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,177,937,740.0	1,016,636,344.5	(161,301,395.6)

Дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Авлага данс 3,249,922.8 мянган төгрөгөөр буурахад ИНЕГ-ын даргын зөвлөлийн 2025 оны 25/07/01 дугаар шийдвэр, ИНЕГ-ын даргын 2025 оны А/244 тушаалаар 6 агаарын тээвэрлэгчийн 729,129.6 мянган төгрөг, ИНЕГ-ын даргын зөвлөлийн 2025 оны 25/07/02 дугаар шийдвэрээр 1,183,206.0 мянган төгрөгийн “Аэромонголиа” ХХК-ийн хуримтлагдсан авлагуудыг барагдуулсан нь голлон нөлөөлсөн;
- Бараа материал данс 5,585.1 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2025 оны 116 дугаар тогтоол, ИНЕГ-ын даргын 2025 оны А/205 дугаар тушаалаар 5,950,915.2 мянган төгрөгийн ТС-1 шатахуун орлогоор авснаас шалтгаалсан;
- Үндсэн хөрөнгийн данс 166,126,529.2 мянган төгрөгөөр буурахад ТӨБЗГ-ын 2025 оны 677 дугаар тогтоолоор “Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба”-нд балансаас балансад шилжүүлсэн хөрөнгө 377,694.9 мянган төгрөг, тайлант онд бэлтгэсэн болон шилжүүлэн авсан хөрөнгө 29,773,838.0 мянган төгрөг голлон нөлөөлсөн;
- Өр төлбөр өмнөх оноос 994,222.1 мянган төгрөгөөр буурахад хөрөнгө оруулалтын барьцаа дансны өглөгөөс гэрээний хугацаа дуусгавар болсон харилцагч нарын барьцаа төлбөр 558,969.2 мянган төгрөгийг чөлөөлсөн, мөн захиалгат нислэгт гадаадын агаарын тээвэрлэгчдийн барьцаа 481,300.0 мянган төгрөгийн төлбөрийг буцаан олгосноос шалтгаалсан;
- Цэвэр хөрөнгө/өмчийн дүн 161,301,395.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн захирагч нь 2025 оны төсвийн төсөлд 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхэд урсгал зардлыг 16,465,719.5 мянган төгрөгөөр төлөвлөж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагчийн төсвийн саналаас 11,977,925.3 мянган төгрөгөөр бууруулж, 4,487.794.2 мянган төгрөгөөр баталжээ. Үүнд: Урсгал зардлаас цалин, хөлс болон нэмэгдэл урамшлыг 6,167,297.2 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 721,971.7 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 203,168.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 213,350.0 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 1,021,440.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг 1,309,868.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,793,000.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 15,221.6 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 12,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмж баталсан нь голлон нөлөөлсөн байна.

Тайлант онд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орж, урсгал санхүүжилтийг батлагдсан төсвөөс 430,538.6 мянган төгрөгөөр бууруулж 4,057,255.6 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: Урсгал зардлаас цалин, хөлс болон нэмэгдэл урамшлыг 132,304.4 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 65,478.6 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 22,115.0 мянган төгрөгөөр хангамж, бараа материалын зардлыг 20,107.3 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 15,026.4 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 10,310.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг 8,590.6 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан нь голлон нөлөөлсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 1 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 3,640,669.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, урсгал зардалд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,648,532.3 мянган төгрөг 85.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 416,586.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
1	71104 Агаарын тээвэр	4,057,255.6	3,468,532.3	588,723.4	85.5
2	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	3,298,862.5	3,241,331.5	57,531.0	98.3
3	80509 Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	179,267.4	-	179,267.4	-
4	80202 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	579,125.7	227,200.7	351,925.0	39.2
	Нийт дүн	4,057,255.6	3,468,532.3	588,732.4	85.5

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

- Тайлант онд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн 9 хувийн цомхотголтой холбоотойгоор 106 орон тооноос 10 орон тоо хасаж 96 болгон бууруулж бүтэц орон тоогоо шинэчлэн баталсан;
- Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/335 дугаар тушаалаар нэг ажилтанд ногдох хоолны хөнгөлөлтийн хэмжээг өдрийн 40.0 мянган төгрөгөөр тогтоосон;
- Тайлант онд нийт 52 удаагийн гадаад албан томилолт, сургалтын арга хэмжээнд 869,720.4 мянган төгрөгийг зарцуулсан байна. Аудитаар гадаад болон дотоод албан томилолтын зардалтай холбоотой гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаагүй, эрх бүхий байгууллагын тушаал шийдвэр удирдамжгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, бусад байгууллагын албан хаагчдад томилолтын зардал олгосон зэрэг нийт 220,317.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн;
- Төрийн захиргааны албан хаагчийн мэргэшүүлэх багц сургалтад 38 (тэргүүн түшмэлийн 1, эрхэлсэн түшмэл-7, ахлах түшмэл-4, мэргэшүүлэх дунд-7, анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх болон чиглүүлэх сургалт-19) ажилтныг улсын төсвийн санхүүжилт болон байгууллагын захиалгаар сургаж, гэрчилгээжүүлсэн;
- Үндсэн хөрөнгийн дансанд санхүү, нягтлан бодох бүртгэлийн 4, албан хэрэг хөтлөлтийн 2, үндсэн үйл ажиллагаатай холбоотой 4 нийт 10 программ бүртгэлтэй

бөгөөд үүнээс санхүү, нягтлан бодох бүртгэлийн Veritech ERP программ, албан хэрэг хөтлөлтийн IMCAA программыг үйл ажиллагаандаа ашигладаг.

- Эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээс шалтгаалж ажлаас чөлөөлөгдсөн албан тушаалтанд шүүхийн шийдвэрийн дагуу байгууллагаас нөхөн олговрыг олгоогүй;
- Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас ирэх аудитын шалгалт болон Монгол улсад иргэний нисэх хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойн үйл ажиллагаа, Иргэний нисэхийн тухай хууль, цаг үеийн шинжтэй мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах зорилгоор нэр бүхий 4 байгууллагатай гэрээ байгуулж 69,698.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Зам, тээврийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/17 дугаар тушаалаар 4 төсөл, арга хэмжээнд өөрийн орлогоос 2,240,000.0 мянган төгрөгийг тухайн онд санхүүжүүлэхээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна.

Зам, тээврийн сайдын 2025 оны А/241 дүгээр тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд туссан 2 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг нийт 530,324.0 мянган төгрөгөөр нэмж баталсан байна. ИНЕГ-ын 2025 оны А/271 дүгээр тушаалаар урсгал зардлын хөрөнгөөр 4 төсөл, арга хэмжээг 453,530.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Тайлант онд худалдан авах ажиллагааны өөрийн орлогоос санхүүжих арга хэмжээний хэрэгжилт 100 хувь, урсгал зардлаас санхүүжих арга хэмжээ 88.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Иргэний нисэхийн ерөнхий газар түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хөрөнгийг холбогдох тушаал шийдвэр, журмын дагуу бүртгэж тайлагнах, хөрөнгийн ашиглалттай холбоотой асуудлыг эрх бүхий байгууллагад хандах шийдвэрлүүлэх, албан хаагчдыг төрийн албан хаагчийн ангилал, зэрэглэлд хамруулах, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй зарцуулах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Энхжаргал, аудитор Ж.Мөнхбилгүүн нар гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01/116 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлан, суурь үзүүлэлтийг нийт зардлын дүнгээс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн нийт зардлын дүн 94,502,916.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 945,029.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн ерөнхийлөн захирагч нь албан хаагчдад хэмнэлтийн горимд шилжин ажиллах талаар үүрэг чиглэл өгч, бичиг хэрэг, ашиглалтын зардлыг хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 47 горим хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Аудитаар 79,813.1 мянган төгрөгийн дараах зөрчил илэрсэн. Үүнд:

1. Бэлэг дурсгалын зүйлс худалдан авахад 36,909.5 мянган төгрөг;
2. Тэмцээн, уралдаан зохион байгуулахтай холбоотой 21,923.6 мянган төгрөг;
3. Тээврийн хэрэгслийн дулаан зогсоолын түрээс 20,980.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан;
4. Тайлант онд орлогоор бүртгэсэн тээврийн хэрэгслийн улсын дугаар нь бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугааргүй;
5. Нэр бүхий 9 албан тушаалтан албан тушаалын суудлын автомашин ашиглаж байна.

Эдгээр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан

тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно", 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ", 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон, хязгаарласан арга хэмжээ зохион байгуулсан, санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 873,313.0 мянган төгрөгийн 7 зөрчилд албан шаардлага, 2 зөрчилд зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Иргэний нисэхийн ерөнхий газар нь Шилэн дансны мэдээллийн цахим хуудсанд байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан, Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг иж бүрэн байршуулаагүй байна. Тайлант онд Иргэний нисэхийн ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн дотоод аудит үр нөлөөгүй, хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.2-т "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор", 6.10-т "Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулаагүй, дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1: ИНЕГ-ын албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

1. ИНЕГ-ын даргын 2025 оны А/104 дүгээр тушаалаар "Цалин хөлсний сүлжээ"-г батлахдаа Засгийн газрын тохируулагч агентлагийн албан хаагчдын цалингийн хэмжээ, шатлалыг баримтлаагүй;

2. ИНЕГ-ын албан хаагчдыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албан хаагчийн ангилал, зэрэглэлд хамруулаагүй;
3. Ерөнхий менежер, Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга нар нь Албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжил, боловсролын тусгай шаардлагыг хангаагүй;
4. ЗТС-ын 2025 оны А/256 дугаар тушаал, ИНЕГ-ын даргын А/324 дүгээр тушаалаар "ИНЕГ-ын бүтэц орон тоо"-г шинэчлэн батлахдаа МУЕС-ын 2025 оны 04 дүгээр "Албан даалгавар"-т удирдах албан тушаалтны орон тоог бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй, байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хамаарах 2 байцаагчийн орон тоог бууруулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-т "Дараах албан тушаалтан төсвийн шууд захирагч байна: 16.4.5.агентлагийн дарга тус агентлагийн төсвийн", Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1. "Агентлаг нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн", Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаас баталсан "Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллагын болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ", Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Төрийн захиргааны албан тушаалд төрийн бодлого боловсруулахад мэргэшлийн зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах, зохион байгуулах чиг үүрэг бүхий дараах албан тушаал хамаарна: 12.1.6.хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын агентлагийн удирдах, гүйцэтгэх албан тушаал", МУЕС-ын 2025 оны 04 дүгээр "Албан даалгавар"-ын 1.2-т "Төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад даалгасан", ИНЕГ-ын 2023 оны А/390 дүгээр тушаал, 2025 оны А/67 дугаар тушаал, 2025 оны А/112 дугаар тушаалаар баталсан "Албан тушаалын тодорхойлолт"-той тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан хаагчдыг Төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэлд хамруулах, цалин хөлсийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэх зөвлөмж хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Иргэний нисэхийн ерөнхий газрыг УИХ, Засгийн газрын тогтоолуудаар Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг болгон тогтоосон ч Хуулийн этгээдийн улсын бүртгэлд Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар хэлбэрээр бүртгэлтэй, Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн "Байгууллагын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийг эрх бүхий байгууллагын шийдвэрт нийцүүлэх" зөвлөмж хэрэгжээгүй, зөрчил давтагдан гарсан байна.

Энэ Засгийн газрын 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан "Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн жагсаалт", 2024 оны 189 дүгээр "Засгийн газрын агентлагийг өөрчлөн байгуулах тухай" тогтоол", Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Агентлаг нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-т "Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Аудит хийх журам"-ын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Байгууллагын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийг эрх бүхий байгууллагын шийдвэрт нийцүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Байгууллагаас чөлөөлсөн ажилтнуудад тэтгэмж олгосон боловч өөр орон тоон дээр буцаан томилж ажиллуулсан байна. Тухайлбал,

ЗТС-ын 2023 оны А/224 дүгээр “Зохион байгуулалтын бүтэц шинэчлэн батлах тухай” тушаал, ИНЕГ-ын даргын 2023 оны А/253 дугаар “Орон тоо, ажлын байрны жагсаалт шинэчлэн батлах тухай” тушаалаар бүтцийн өөрчлөлтөөр дотоод аудитын албаны менежерийг орон тоо хасагдсанаас ажлаас чөлөөлж, Б/169 дүгээр тушаалаар 31,327.9 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон байна. ИНЕГ-ын даргын 2025 оны Б/48 дугаар тушаалаар тус ажилтныг Иргэний нисэхийн бодлогын хэрэгжилтийн газрын менежер, Б/90 дүгээр тушаалаар Захиргаа удирдлага, хууль эрх зүйн газрын даргаар тус тус ажилд эргүүлэн томилсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 16 дугаар зүйлийн 16.5.9-д "дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ажлаас чөлөөлж тэтгэмж олгосон ажилтныг өөр орон тоон дээр буцаан томилдог зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 4: ЗТС-ын 2024 оны А/89 дүгээр тушаал, ЗТС, БХС-ын сайдын хамтарсан 2025 оны А/07-07 дугаар тушаалаар "Монгол улсад нисэх хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэх"-ээр тус тус баталсан байна.

Зам, тээврийн сайдын 2025 оны А/17 дугаар тушаалаар салбарын ой тэмдэглэх арга хэмжээний зардлыг 1,100,000.0 мянган төгрөгөөр, 2025 оны А/241 дүгээр тушаалаар 1,300,000.0 мянган төгрөгөөр тус тус баталж гүйцэтгэлээр 1,066,353.8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Тухайлбал,

1. Ойн арга хэмжээний урлагийн тоглолтод 119,509.5 мянган төгрөг;
2. Уран нислэгийн үзүүлбэрт 19,900.0 мянган төгрөг;
3. Ойн арга хэмжээний зөвлөх үйлчилгээний төлбөрт 19,500.0 мянган төгрөг;
4. Хурал, зөвлөгөөн, уулзалт зохион байгуулахад 179,218.6 мянган төгрөг;
5. Дурсгалын зоос хэвлүүлэхэд 80,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д "сахилга баттай байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төсвийн хөрөнгийг хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зөвлөмж өгсөн.

Илрүүлэлт 5: Байгууллагын бүтэц, орон тоотой холбоотой дараах асуудлууд илэрсэн. Үүнд:

1. Зам, тээврийн сайдын 2024 оны А/289 дүгээр тушаал, 2025 оны А/256 дугаар тушаал, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2024 оны А/631 дүгээр тушаалаар "ИНЕГ-ын орон тоо, ажлын байрны жагсаалт"-ыг тус тус батлахдаа дэд даргын орон тоог баталсан;

2. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2025 оны А/47 дугаар тушаалаар Ерөнхий менежерийн орон тоог нэмж бий болгож, мөн оны А/104 дүгээр "Цалин хөлсний сүлжээг шинэчлэн батлах тухай" тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газрын дэд дарга, ерөнхий менежерийн албан тушаалын цалингийн сүлжээг тус тус тусгаж баталсан;

3. Ерөнхий менежерийн орон тоонд 1 ажилтныг томилон ажиллуулж, 5-12 дугаар сарын хугацаанд нийт 62,617.6 мянган төгрөгийн цалин хөлс олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Хуульд тусгайлан заагаагүй бол төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг Засгийн газрын агентлаг, Засгийн газрын ажлын алба, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага, эмнэлэг, төрийн болон орон нутгийн өмчийн их сургууль, төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компаниас бусад этгээд тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглоно", 5.4-т "Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно", Засгийн газрын 2025 оны 52 дугаар тогтоолын 4 дүгээр зүйл "Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн зохион байгуулалтын бүтцийг батлахдаа дараах чиглэлийг баримталж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай:", 4.1-д "хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын агентлаг нь дэд дарга, орлогч даргагүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь:

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын тогтоолоор хориглосон орон тоо, албан тушаал бий болгосон зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 6: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэгт хамааралгүй дараах чиглэлээр гадаад албан томилолтоор ажиллуулж, нийт 47,352.3 мянган төгрөгийн томилолтын зардлыг олгосон байна. Үүнд:

1. ИНЕГ-ын даргын 2025 оны А/123 дугаар тушаалаар "Тайландад Иргэний нисэхийн сургалтын төвтэй харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах" гадаад томилолтын зардал 9,480.3 мянган төгрөг;

2. ИНЕГ-ын даргын 2025 оны А/163 дугаар тушаалаар "БНХАУ-ын Шанхайн олон улсын сансрын технологи, тоног төхөөрөмжийн үзэсгэлэнд оролцох" гадаад томилолтын зардал 8,555.9 мянган төгрөг;

3. ИНЕГ-ын даргын 2025 оны А/264 дүгээр тушаалаар "АНУ-ын Холбооны нисэхийн захиргаатай хийх уулзалт"-д оролцох гадаад томилолтын зардал 16,406.4 мянган төгрөг;

4. Тушаал шийдвэргүйгээр "Үндэсний болон олон улсын усан хилийн агаарын зайд хүнгүй нисэх төхөөрөмжийн системийг нэгтгэх" сэдэвт семинарт оролцох томилолтын зардал 12,909.7 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", ИНЕГ-ын даргын 2023 оны А/390 дүгээр тушаалаар баталсан "ХШҮДАА-ны даргын албан тушаалын тодорхойлолт"-ын албан тушаалын зорилго "Хууль тогтоомж, бодлого, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулахад, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахад болон хөрөнгө оруулалтын үр нөлөөг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, эрсдэлийн удирдлагаар хангах чиг үүргийн хүрээнд нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг даргын өмнө хариуцах", Албан тушаалын зорилт: 1. Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэр, дүрэм, журам, заавар, стандарт, бодлого, гэрээний биелэлтэд дотоод аудит, хяналт шалгалт хийж, байгууллагын үйл ажиллагааг дэмжих, эрсдэлийн удирдлагын үйл явцыг шалгах, үнэлэх, тайлагнах, сайжруулахад мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах, 2. Бодлого, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр, тогтоол шийдвэр, албан даалгавар, тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнд үнэлгээ өгч,

удирдлагыг болон бусад хэрэглэгчдийг мэдээлэл болон мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах", "Нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар хангах", "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэгт хамааралгүй ажилтныг гадаад албан томилолтоор ажиллуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 7: Худалдан авах ажиллагаатай холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2025 оны А/271 дүгээр тушаалаар "2025 оны өөрийн орлого болон урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжих худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-г шинэчлэн батлахдаа тайлант онд хэрэгжих боломжгүй нийт 453,530.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.

2. Нийт 630,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны гишүүд Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх мэдэгдлийг бөглөөгүй, үнэлгээний хорооны гишүүдийн худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан эсэх нь тодорхойгүй, тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтыг хэлэлцэх, сонгон шалгаруулах тендер нээх, үнэлэх хуралдааны тэмдэглэлгүй, хуралдааны тэмдэглэл иж бүрэн бус, тэмдэглэлд дарга, гишүүд гарыг үсэг зурж баталгаажуулаагүй нь хуралдаанд ирц бүрэн оролцсон эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

3. Нийт 53,530.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалттай Сангийн яам тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлын дагуу 2 удаагийн тендер шалгаруулалтыг хянаж тендер үнэлэх ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, үнэлгээний хорооны шийдвэрийг үндэслэлгүй гэж үзэн хүчингүй болгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 50 дугаар зүйлийн 50.3-т "Үнэлгээний хорооны гишүүн худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан байна", 51 дүгээр зүйлийн 51.3-т "Үнэлгээний хороо нийт гишүүний дөрөвний гурваас багагүй тооны гишүүний ирцтэй хуралдсанаар хурлыг хүчинтэйд тооцно", 51.8-д "Үнэлгээний хорооны гишүүд хуралд биечлэн оролцсон эсэхээс үл хамааран зөвлөмжтэй танилцаж, түүнийг дэмжих эсэх саналаа тусган цахим системээр баталгаажуулах үүрэгтэй", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-т "төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх", Сангийн сайдын 2023 оны 250 дугаар тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.12-т "Батлагдсан төлөвлөгөөнд дараах тохиолдлоос өөр үндэслэлээр нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно:", 2.12.1-д "тухайн жилийн төсөвт тодотгол хийсэн, хуульд заасан бусад эх үүсвэр батлагдсан, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлд зааснаар төсөвт зохицуулалт хийсэн", 2.12.2-т "энэ журмын 1.7-д заасан захиалагчийн тухайн онд хэрэгжүүлэхээр батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол, хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагааг хэвийн явуулахад хүндрэл үүссэн" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн батлахдаа тайлант онд хэрэгжих боломжгүй шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг нэмж баталдаг, Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулдаггүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулан, мөнгөн хөрөнгө, цалингийн зардал, бараа материал болон үндсэн хөрөнгийн данстад аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.

Аудитын үр дүнд нийт 17,817,257.2 мянган төгрөгийн дүн бүхий 10 алдаа, зөрчил илэрсэн бөгөөд эдгээр асуудлын хэрэгжилт, залруулсан байдлыг жилийн эцсийн аудитаар дахин хянан шалгаж, үр дүнг аудитын тайланд тусгасан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх онд тус албаны санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн хэрэгжүүлж, аудитаар илэрсэн зөрчлөөс 92,345,890.0 мянган төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага хүргүүлснээс 21,527,744.6 мянган төгрөгийн 3 албан шаардлага бүрэн хэрэгжсэн, 16,269,255.2 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 5 зөвлөмжөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Албан шаардлага	10	92,345,890.0	3	21,527,744.6	79.0
2	Зөвлөмж	5	16,269,255.2	3	16,269,255.2	67.0
	Нийт дүн	15	108,615,145.2	6	37,796,999.8	73.0

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн Байгууллагын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийг эрх бүхий байгууллагын шийдвэрт нийцүүлэх, Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, зөрчил давтан гарсан тул таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Өмнөх оны аудитаар илэрсэн нийт 70,818,145.5 мянган төгрөгийн зөрчилд хүргүүлсэн 7 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тул зөрчлийг арилгах, таслан зогсоох албан шаардлагуудын хэрэгжилтийг хангах үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах асуудлуудыг авч үзэх нь зүйтэй байна. Үүнд:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын бүтэц, зохион байгуулалт, хуулийн этгээдийн олон хэлбэрийг хууль, эрх бүхий байгууллагын шийдвэрт нийцүүлэх, олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, дүрэм, зөвлөмжид нийцсэн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх;
2. Иргэний нисэхийн ерөнхий газрын орлого, зарлагын төлөвлөгөөг бодитой төлөвлөөгүйгээс орлогын төлөвлөгөө тасарсан зөрчил давтан гарсан.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар УСНББОУС 1, 17, 24, 27 дугаар заалтад нийцээгүй нийт 300,783.6 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Гадаад албан томилолтын зардал нийт 102,783.6 мянган төгрөгийг аудит баталгаажуулалт, урьдчилж төлсөн тооцоонд бүртгэсэн.
- ЗТЯ-аас ТӨБЗГ-ын 2025 оны 621 дүгээр тогтоолоор ИНЕГ-т шилжүүлсэн 198,000.0 мянган төгрөгийн балансын үнэ бүхий тээврийн хэрэгслийг бүртгээгүй;
- Санхүүгийн байдлын тайлан, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд элэгдлийн дүнг 487.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;

Аудитаар нийт 2,409,955.2 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд, 76,431.9 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 1,589,824.9 мянган төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага хүргүүлж, 743,698.4 мянган төгрөгийн 5 зөвлөмж, 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн өгсөн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 2,409,955.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,464,926.0 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Гадаад болон дотоод албан томилолтоор ажилласан 34 албан хаагчийн цалин хөлсийг тооцоолохдоо, томилолтоор ажилласан хугацаанд нийт 7,700.0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан томилолтын зардалтай давхардуулан олгосон хоолны хөнгөлөлт 7,700.0 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт 2: ИНЕГ-ын даргын 2025 оны А/630 дугаар тушаалаар гадаад улс оронд 53 хоногийн хугацаанд суралцсан нэр бүхий 1 албан хаагчид ИНЕГ-ын даргын 2024 оны А/408 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу сар бүр дундаж цалингийн 70 хувьтай тэнцэх тэтгэмж олгоггүйгээр бүтэн ажилласнаар тооцож 3,477.7 мянган төгрөгийн тэтгэмж илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2024 оны А/408 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8.1.2-т Суралцах хугацаанд 8.1.2.а "Байгууллагын захиалгаар 1-3 сарын хугацаагаар үндсэн ажлаасаа чөлөөлөгдөн сургалтад хамрагдсан тохиолдолд суралцах хугацааны сар тутамд тухайн ажилтны сарын дундаж цалингийн 70 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг олгоно", Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2024 оны А/630 дугаар тушаалын 2-т "Гадаад сургалтад хамруулахтай холбогдон гарах зардлыг батлагдсан төсвийн дагуу гарган зарцуулах, суралцах хугацааны сар тутамд дундаж цалингийн 70 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгохыг тус тус Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст зөвшөөрсүгэй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Илүү олгосон тэтгэмж 3,477.7 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт 3: Хөрөнгийн барьцаа дансанд 7 гүйцэтгэгч байгууллагын 65,254.2 мянган төгрөгийн 3-аас дээш жилийн насжилттай барьцаа төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийн зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Хөрөнгийн барьцаа дансанд бүртгэлтэй 65,254.2 мянган төгрөгийн барьцаа төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Тайлант хугацаанд нийт 37,072,972.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй ба үүнээс 433,091.5 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй. Нийт 287,707.9 мянган төгрөгийн авлага нь 5-аас дээш жилийн насжилттай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Олон жилийн насжилттай авлагыг үе шаттай бууруулах ажлыг зохион байгуулах, тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Санхүүгийн тайланд нийт 21,608,194.4 мянган төгрөгийн шийдвэрлээгүй өр төлбөрийн үлдэгдэлтэй ба 933,376.5 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Үүнээс 1,579,919.3 мянган төгрөгийн өр төлбөр нь 5-аас дээш жилийн насжилттай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого

хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, олон жилийн насжилттай өр төлбөрийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 3: ЗТС-ын 2025 оны өдрийн А/17 дугаар тушаалаар ИНЕГ-ын 2025 оны агаарын навигацийн орлогын төлөвлөгөөг 298,635,990.8 мянган төгрөгөөр, А/241 дүгээр тушаалаар 302,631,641.6 мянган төгрөгөөр тус тус баталжээ. Орлогын төлөвлөгөөг тодотголоор тооцоо, судалгаа хангалтгүй, тооцоололгүйгээр анх төлөвлөснөөс 3,995,950.8 мянган төгрөгөөр нэмж баталснаас гүйцэтгэлээр орлогын төлөвлөгөө 3,228,013.4 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", 41 дүгээр зүйлийн 41.2. "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ:", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Зам, тээврийн сайдын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/241 дүгээр тушаалаар баталсан "2025 оны орлого, зарлагын төлөвлөгөө"-тэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Навигацийн орлогыг бодитой төлөвлөөгүй, төлөвлөгөөг биелүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 4: Гадаад албан томилолтын хэрэгжээгүй зардал виз, торгууль төлсөн дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

1. Зам, тээврийн сайдын гадаад томилолтын тушаалд нэр тусгагдаагүй, томилолтоор ажиллаагүй 2 албан хаагчийн визний төлбөрт 2,227.0 мянган төгрөгийг зарцуулсан;
2. Зам, тээврийн яамны чиглэл, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2025 оны А/317 дугаар тушаалаар гадаад албан томилолтыг цуцалснаас 2,141.1 мянган төгрөгийг онгоцны тийзийн торгуульд төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төсвийг үр ашиггүй зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 5: Эрх бүхий байгууллага, албан тушаалтны тушаал шийдвэр, удирдамжгүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар албан томилолтын 127,654.4 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Томилолтын тушаал шийдвэргүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар зардлыг санхүүжүүлдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 6: Гадаад албан томилолтын тушаал, батлагдсан төсөвт тусгагдаагүй уулзалтын зардалд 22,967.4 мянган төгрөг, нисэхийн салбарын бусад байгууллагын албан хаагчдын гадаад томилолтын зардалд 26,576.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Гадаад томилолт, арга хэмжээний зардлын төсөвт тусгаагүй зардлыг санхүүжүүлсэн, бусад байгууллагын ажилтнуудад томилолтын зардлыг олгосон зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 7: Гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаагүй сургалтын зардалд 38,751.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2025 оны А/69 дүгээр тушаалаар баталсан "Гадаад арга хэмжээний төлөвлөгөө"-нд тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаагүй сургалтын зардлыг санхүүжүүлдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 8: Хөрөнгийн барьцаа данс нь 1,216,046.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд төлбөрийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.2.5-д "төсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Чанарын баталгааны барьцаа хөрөнгийг үндсэн үйл ажиллагааны харилцах данснаас тусад нь байршуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 9: Нийт 720,572.6 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 6 тээврийн хэрэгслийг ЗТЯ, ИНУТ ТӨХХК, орон нутаг дахь нисэх буудалд үнэ төлбөргүйгээр ашиглуулж байгаа ба тээврийн хэрэгслийн дулаан зогсоолын зардалд 3,040.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч

дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг бусдад үнэ төлбөргүй ашиглуулсан, үр ашиггүй зардал гаргасан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 10: Албан хаагчдын үр дүнгийн урамшууллыг Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан журамд заасан улирлын мөнгөн урамшууллын дээд хэмжээг хэтрүүлэн сар бүр 40 хувиар тооцож нийт 1,340,473.6 мянган төгрөгийг, ИНЕГ-ын 2025 оны 372 дугаар тушаалаар ажилтнуудын жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, гүйцэтгэлийн тайланг тус тус үндэслэн 5,000.0 мянган төгрөг хүртэлх нэмэгдэл хөлс нийт 463,218.2 мянган төгрөгийг тус тус олгосон байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Нэмэгдэл, урамшууллыг холбогдох журамд зааснаас хэтрүүлэн олгодог зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Сахилгын шийтгэл

Илрүүлэлт: Өмнөх оны аудитаар өгсөн нийт 70,818,145.5 мянган төгрөгийн 7 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлүүд давтагдан гарсан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Аудит хийх журам"-ын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Өмнөх оны аудитаар өгсөн зөрчил арилгах, таслан зогсоох албан шаардлагуудын хэрэгжилтийг хангах үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Төрбаярт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Тайлант онд Иргэний нисэхийн үндэсний төв ТӨХХК-аас шилжүүлэн авсан 7,268,732.1 мянган төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 1.2. Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг холбогдох тушаал шийдвэр, журмыг үндэслэн бүртгэж тайлагнах.

Илрүүлэлт 2: Хөрөнгөд бүртгэлтэй нийт 449,457.4 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээгүй, ашиглалтгүй байгаа өвлийн 2 давхар 7 ширхэг байшинг эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах"; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 1.2. Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтгүй хөрөнгийг эрх бүхий байгууллагад хандах шийдвэрлүүлэх.

Илрүүлэлт 3: Хөрөнгөд бүртгэлтэй 15,124.1 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 16 кв.м 1 өрөө орон сууц, 139,558.4 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй тээврийн хэрэгсэл тус тус иргэн болон бусад байгууллагын нэр дээр гэрчилгээтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах"; Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4."эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл" гэж өмчийн хэлбэр, өмчлөгчийн иргэний харьяалал харгалзахгүйгээр Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгийн эрх үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой хуульд заасан бүртгэлийн үйл ажиллагааг", Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3."хувийн хэрэг" гэж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд байгаа цаасан болон цахим нотлох баримт бичгийн бүрдлийг", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 1.2. Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгөд бүртгэлтэй, бусад байгууллагын нэр дээр гэрчилгээтэй хөрөнгийн эзэмших эрхийг шилжүүлэх асуудлыг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх.

2. Дотоод албан томилолттой холбоотой асуудал

Илрүүлэлт: Дотоод албан томилолтын зардлыг тооцохдоо Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалаар баталсан зардлын хэмжээг мөрдөөгүй, сумд ажиллах томилолтын зардлыг аймгийн төвөөр тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалаар баталсан “Дотоод албан томилолтын зардлын хэмжээ”-нд тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрх бүхий байгууллагаас баталсан “Дотоод албан томилолтын зардлын хэмжээ”-г мөрдөж ажиллах.

3. Тээврийн хэрэгсэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Хөрөнгөд нийт 15 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй ба ТӨБЗГ-ын 2025 оны 652 дугаар тогтоолоор “ИНЕГ-ын дотоод албан ажлын хэрэгцээнд ашиглагдах автомашины ангилал, тоо төрөл”-ийг нийт 11 автомашиныг ашиглахаар баталсан, ТӨБЗГ-ын тогтоолоос илүү 4 автомашины талаар эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно”, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, ТӨБЗГ-ын 2025 оны 652 дугаар тогтоолд тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрх бүхий байгууллагаас албан хэрэгцээнд зориулан баталсан тээврийн хэрэгслийн тоо, төрлийг баримталж илүү тээврийн хэрэгслийг шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Гадаад албан томилолтын зардал нийт 102,783.6 мянган төгрөгийг аудит баталгаажуулалт, урьдчилж төлсөн тооцоонд бүртгэсэн.	1	102,783.6			1	102,783.6	1	102,783.6				
2	ЗТЯ-аас ТӨБЗГ-ын 2025 оны 621 дүгээр тогтоолоор ИНЕГ-т шилжүүлсэн 198,000.0 мянган төгрөгийн балансын үнэ бүхий тээврийн хэрэгслийг бүртгээгүй;	1	198,000.0	1	198,000.0			1	198,000.0				
3	Санхүүгийн байдлын тайлан, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд элэгдлийн дүн 487.5 мянган төгрөгөөр зөрүүтэй;	1	487.5			1	487.5	1	487.5				
	Дүн	3	301,271.1	1	198,000.0	2	103,271.1	3	301,271.1				

6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Тайлант онд ИНУТ ТӨХХК-аас шилжүүлэн авсан 7,268,732.1 мянган төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр бүртгэсэн байна.	1	-							1	-		
2	Хөрөнгөд бүртгэлтэй нийт 449,457.4 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээгүй, ашиглалтгүй байгаа өвлийн 2 давхар 7 ширхэг байшинг эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлээгүй байна.	1	449,457.4							1	449,457.4		

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3	Хөрөнгөд бүртгэлтэй 15,124.1 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 16 кв.м 1 өрөө орон сууц, 139,558.4 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй тээврийн хэрэгсэл тус тус иргэн болон бусад байгууллагын нэр дээр гэрчилгээтэй байна.	1	154,682.5					1	154,682.5		
4	Тайлант хугацаанд нийт 37,072,972.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй ба үүнээс 433,091.5 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй. Нийт 287,707.9 мянган төгрөгийн авлага нь 5-аас дээш жилийн насжилттай байна.	1	433,091.5			1	433,091.5				
5	Санхүүгийн тайланд нийт 21,608,194.4 мянган төгрөгийн шийдвэрлээгүй өр төлбөрийн үлдэгдэлтэй ба 933,376.5 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Үүнээс 1,579,919.3 мянган төгрөгийн өр төлбөр нь 5-аас дээш жилийн насжилттай байна.	1	933,376.5			1	933,376.5				
6	ЗТС-ын 2025 оны өдрийн А/17 дугаар тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны агаарын навигацийн орлогын төлөвлөгөөг 298,635,990.8 мянган төгрөгөөр, А/241 дүгээр тушаалаар 302,631,641.6 мянган төгрөгөөр тус тус баталжээ. Орлогын төлөвлөгөөг тодотголоор тооцоо, судалгаа хангалтгүй, тооцоололгүйгээр анх төлөвлөснөөс 3,995,950.8 мянган төгрөгөөр нэмж баталснаас гүйцэтгэлээр орлогын төлөвлөгөө 3,228,013.4 мянган төгрөгөөр тасарсан байна.	1	-			1	-				
7	Гадаад албан томилолтын хэрэгжээгүй зардал виз, торгууль төлсөн дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд: 1. Зам, тээврийн сайдын гадаад томилолтын тушаалд нэр тусгагдаагүй, томилолтоор ажиллаагүй 2 албан хаагчийн визний төлбөрт 2,227.0 мянган төгрөгийг зарцуулсан; 2. Зам, тээврийн яамны чиглэл, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2025 оны А/317 дугаар тушаалаар гадаад албан томилолтыг цуцалснаас 2,141.1 мянган төгрөгийг онгоцны тийзийн торгуульд төлсөн байна.	1	4,368.1			1	4,368.1				
8	Эрх бүхий байгууллага, албан тушаалтны тушаал шийдвэр, удирдамжгүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар албан томилолтын 127,654.4 мянган төгрөгийг олгосон байна.	1	127,654.4			1	127,654.4				
9	Гадаад албан томилолтын зардалтай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд: 1. Гадаад албан томилолтын тушаал, батлагдсан төсөвт тусгагдаагүй уулзалтын зардалд 22,967.4 мянган төгрөг, 2. нисэхийн салбарын бусад байгууллагын албан хаагчдын гадаад томилолтын зардалд 26,576.2 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.	1	49,543.6			1	49,543.6				

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

10	Гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаагүй сургалтын зардалд 38,751.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	38,751.0			1	38,751.0				
11	Дотоод албан томилолтын зардлыг тооцохдоо Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалаар баталсан зардлын хэмжээг мөрдөөгүй, сумд ажиллах томилолтын зардлыг аймгийн төвөөр тооцож олгосон байна.	1	-					1		-	
12	Хөрөнгийн барьцаа данс нь 1,216,046.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд төлбөрийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүй байна.	1	-			1	-				
13	Хөрөнгийн барьцаа дансанд 7 гүйцэтгэгч байгууллагын 65,254.2 мянган төгрөгийн 3-аас дээш жилийн насжилттай барьцаа төлбөрийн үлдэгдэлтэй байна.	1	65,254.2	1	65,254.2						
14	Нийт 720,572.6 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 6 тээврийн хэрэгслийг Зам, тээврийн яам, Иргэний нисэхийн үндэсний төв Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, орон нутаг дахь нисэх буудалд үнэ төлбөргүйгээр ашиглуулж байгаа ба тээврийн хэрэгслийн дулаан зогсоолын зардалд 3,040.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.	1	3,040.0			1	3,040.0				
15	Хөрөнгөд нийт 15 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй ба ТӨБЗГ-ын 2025 оны 652 дугаар тогтоолоор "ИНЕГ-ын дотоод албан ажлын хэрэгцээнд ашиглагдах автомашины ангилал, тоо төрөл"-ийг нийт 11 автомашиныг ашиглахаар баталсан, ТӨБЗГ-ын тогтоолоос илүү 4 автомашины талаар эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй байна.	1	-					1		-	
16	Гадаад болон дотоод албан томилолтоор ажилласан 34 албан хаагчийн цалин хөлсийг тооцоолохдоо, томилолтоор ажилласан хугацаанд нийт 7,700.0 мянган төгрөгийн хоол, унааны мөнгийг давхардуулан олгосон байна.	1	7,700.0	1	7,700.0						
17	Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2025 оны А/630 дугаар тушаалаар гадаад улс оронд 53 хоногийн хугацаанд суралцсан нэр бүхий 1 албан хаагчид Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2024 оны А/408 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-д заасны дагуу сар бүр дундаж цалингийн 70 хувьтай тэнцэх тэтгэмж олголгүйгээр бүтэн ажилласнаар тооцож 3,477.7 төгрөгийн тэтгэмж илүү олгосон байна.	1	3,477.7	1	3,477.7						
18	Албан хаагчдын үр дүнгийн урамшууллыг Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан журамд заасан улирлын мөнгөн урамшууллын дээд хэмжээг хэтрүүлэн сар бүр 40 хувиар тооцож нийт 1,340,473.6 төгрөгийг,	1	-			1	-				

**Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

	Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны 372 дугаар тушаалаар ажилтнуудын жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, гүйцэтгэлийн тайланг тус тус үндэслэн 5,000.0 мянган төгрөг хүртэлх нэмэгдэл хөлс нийт 463,218.2 мянган төгрөгийг тус тус олгосон байна.										
19	Өмнөх оны аудитаар нийт 70,818,145.5 мянган төгрөгийн 7 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчил давтан гарсан байна.	1	-							1	1
	Дүн	19	2,270,396.8	3	76,431.9	10	1,589,824.9	5	604,140.0	1	1

6.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

№	Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/					
		Нийт зөрчил		Үүнээс			
		Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд: 1. Шилэн дансны мэдээллийн цахим хуудсанд байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан, Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг иж бүрэн байршуулаагүй; 2. Иргэний нисэхийн ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн дотоод аудит үр нөлөөгүй, хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.	1	-	1	-		
	Дүн	1	-	1	-		
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
1	ИНЕГ-ын албан хаагчдын ангилал, зэрэглэлтэй холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд: 1. ИНЕГ-ын даргын 2025 оны А/104 дүгээр тушаалаар "Цалин хөлсний сүлжээ"-г батлахдаа Засгийн газрын тохируулагч агентлагийн албан хаагчдын цалингийн хэмжээ, шатлалыг баримтлаагүй; 2. ИНЕГ-ын албан хаагчдыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албан хаагчийн ангилал, зэрэглэлд хамруулаагүй; 3. Ерөнхий менежер, Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга нар нь Албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжил, боловсролын тусгай шаардлагыг хангаагүй; 5. ЗТС-ын 2025 оны А/256 дугаар тушаал, ИНЕГ-ын даргын А/324 дүгээр тушаалаар "ИНЕГ-ын бүтэц орон тоо"-г шинэчлэн батлахдаа МУЕС-ын 2025 оны 04 дүгээр "Албан даалгавар"-т удирдах албан тушаалтны орон тоог бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй, байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хамаарах 2 байцаагчийн орон тоог бууруулсан байна.	1	-			1	-
2	ЗТС-ын 2024 оны А/89 дүгээр тушаал, ЗТС, БХС-ын сайдын хамтарсан 2025 оны А/07-07 дугаар тушаалаар "Монгол улсад нисэх хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэх"-ээр тус тус баталсан	1	-			1	-

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	байна. Зам, тээврийн сайдын 2025 оны А/17 дугаар тушаалаар салбарын ой тэмдэглэх арга хэмжээний зардлыг 1,100,000.0 мянган төгрөгөөр, 2025 оны А/241 дүгээр тушаалаар 1,300,000.0 мянган төгрөгөөр тус тус баталж гүйцэтгэлээр 1,066,353.8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Тухайлбал, 1. Ойн арга хэмжээний урлагийн тоглолтод 119,509.5 мянган төгрөг; 2. Уран нислэгийн үзүүлбэрт 19,900.0 мянган төгрөг; 3. Ойн арга хэмжээний зөвлөх үйлчилгээний төлбөрт 19,500.0 мянган төгрөг; 4. Хурал, зөвлөгөөн, уулзалт зохион байгуулахад 179,218.6 мянган төгрөг; 5. Дурсгалын зоос хэвлүүлэхэд 80,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.						
3	Иргэний нисэхийн ерөнхий газрыг УИХ, Засгийн газрын тогтоолуудаар Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг болгон тогтоосон ч Хуулийн этгээдийн улсын бүртгэлд Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар хэлбэрээр бүртгэлтэй; Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн "Байгууллагын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийг эрх бүхий байгууллагын шийдвэрт нийцүүлэх" зөвлөмж хэрэгжээгүй, зөрчил давтагдан гарсан байна.	1	-	1	-		
4	Байгууллагаас чөлөөлсөн ажилтнуудад тэтгэмж олгосон боловч өөр орон тоон дээр буцаан томилж ажиллуулсан байна. Тухайлбал, Зам, тээврийн сайдын 2023 оны А/224 дүгээр "Зохион байгуулалтын бүтэц шинэчлэн батлах тухай" тушаал, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2023 оны А/253 дугаар "Орон тоо, ажлын байрны жагсаалт шинэчлэн батлах тухай" тушаалаар бүтцийн өөрчлөлтөөр дотоод аудитын албаны менежерийг орон тоо хасагдсанаас ажлаас чөлөөлж, Б/169 дүгээр тушаалаар 31,327.9 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон байна. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2025 оны Б/48 дугаар тушаалаар тус ажилтныг Иргэний нисэхийн бодлогын хэрэгжилтийн газрын менежер, Б/90 дүгээр тушаалаар Захиргаа удирдлага, хууль эрх зүйн газрын даргаар тус тус ажилд эргүүлэн томилсон байна.	1	-	1	-		
5	Байгууллагын бүтэц, орон тоотой холбоотой дараах асуудлууд илэрсэн. Үүнд: 1. Зам, тээврийн сайдын 2024 оны А/289 дүгээр тушаал, 2025 оны А/256 дугаар тушаал, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2024 оны А/631 дүгээр тушаалаар "ИНЕГ-ын орон тоо, ажлын байрны жагсаалт"-ыг тус тус батлахдаа дэд даргын орон тоог баталсан; 2. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2025 оны А/47 дугаар тушаалаар Ерөнхий менежерийн орон тоог нэмж бий болгож, мөн оны А/104 дүгээр "Цалин хөлсний сүлжээг шинэчлэн батлах тухай" тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газрын дэд дарга, ерөнхий менежерийн албан тушаалын цалингийн сүлжээг тус тус тусгаж баталсан; 3. Ерөнхий менежерийн орон тоонд 1 ажилтныг томилон ажиллуулж, 5-12 дугаар сарын хугацаанд нийт 62,617.6 мянган төгрөгийн цалин хөлс олгосон байна.	1	62,617.6	1	62,617.6		
6	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэгт хамааралгүй дараах чиглэлээр гадаад албан томилолтоор ажиллуулж, нийт 47,352.3 мянган төгрөгийн томилолтын зардлыг олгосон байна. Үүнд: 1. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2025 оны А/123 дугаар тушаалаар "Тайландад Иргэний нисэхийн сургалтын төвтэй харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах" гадаад томилолтын зардал 9,480.3 мянган төгрөг; 2. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2025 оны А/163 дугаар тушаалаар "БНХАУ-ын Шанхайн олон улсын сансрын технологи, тоног төхөөрөмжийн үзэсгэлэнд оролцох" гадаад томилолтын зардал 8,555.9 мянган төгрөг; 3. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2025 оны А/264 дүгээр тушаалаар "АНУ-ын Холбооны	1	47,352.3	1	47,352.3		

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	нисэхийн захиргаатай хийх уулзалт"-д оролцох гадаад томилолтын зардал 16,406.4 мянган төгрөг; 4. Тушаал шийдвэргүйгээр "Үндэсний болон олон улсын усан хилийн агаарын зайд хүнгүй нисэх төхөөрөмжийн системийг нэгтгэх" сэдэвт семинарт оролцох томилолтын зардал 12,909.7 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.					
7	Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон үйл ажиллагаатай холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд: 1. Бэлэг дурсгалын зүйлс худалдан авахад 36,909.5 мянган төгрөг; 2. Тэмцээн, уралдаан зохион байгуулахтай холбоотой 21,923.6 мянган төгрөг; 3. Тээврийн хэрэгслийн дулаан зогсоолын түрээс 20,980.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан; 4. Тайлант онд орлогоор бүртгэсэн тээврийн хэрэгслийн улсын дугаар нь бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугааргүй; 5. Нэр бүхий 9 албан тушаалтан албан тушаалын суудлын автомашин ашиглаж байна.	1	79,813.1	1	79,813.1	
8	Худалдан авах ажиллагаатай холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд: 1. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2025 оны А/271 дүгээр тушаалаар "2025 оны өөрийн орлого болон урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжих худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-г шинэчлэн батлахдаа тайлант онд хэрэгжих боломжгүй нийт 453,530.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан. 2. Нийт 630,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны гишүүд Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх мэдэгдлийг бөглөөгүй, үнэлгээний хорооны гишүүдийн худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан эсэх нь тодорхойгүй, тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтыг хэлэлцэх, сонгон шалгаруулах тендер нээх, үнэлэх хуралдааны тэмдэглэлгүй, хуралдааны тэмдэглэл иж бүрэн бус, тэмдэглэлд дарга, гишүүд гарыг үсэг зурж баталгаажуулаагүй нь хуралдаанд ирц бүрэн оролцсон эсэхийг тодорхойлох боломжгүй байна. 3. Нийт 53,530.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалттай Сангийн яам тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлын дагуу 2 удаагийн тендер шалгаруулалтыг хянаж тендер үнэлэх ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, үнэлгээний хорооны шийдвэрийг үндэслэлгүй гэж үзэн хүчингүй болгосон байна.	1	683,530.0	1	683,530.0	
	Дүн	8	873,313.0	6	873,313.0	2
	Нийт дүн	9	873,313.0	7	873,313.0	2



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 20/А0170104

Улаанбаатар хот

САГ-2026/98/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөрөнгийн барьцаа дансанд 7 гүйцэтгэгч байгууллагын 65,254,174.40 /Жаран таван сая хоёр зуун тавин дөрвөн мянга нэг зуун далан дөрвөн төгрөг дөчин мөнгө/ төгрөгийн 3-аас дээш жилийн насжилттай барьцаа төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийн зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон", 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хөрөнгийн барьцаа дансанд бүртгэлтэй 65,254,174.40 /Жаран таван сая хоёр зуун тавин дөрвөн мянга нэг зуун далан дөрвөн төгрөг дөчин мөнгө/ төгрөгийн барьцаа төлбөрийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Төрбаяр/, ерөнхий нягтлан бодогч /Н.Наранцэцэг/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ц.ЭНХЖАРГАЛ
Ж.МӨНХБИЛГҮҮН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26 230

Z:\Akt\2026\0225\SAG-12.Docx

1526200065



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 19/АД170104

Улаанбаатар хот

САГ-2026/98/НА -СТА -ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гадаад болон дотоод албан томилолтоор ажилласан 34 албан хаагчийн цалин хөлсийг тооцоолохдоо, томилолтоор ажилласан хугацаанд нийт 7,700,000.00 /Долоон сая долоон зуун мянган/ төгрөгийн хоол, унааны мөнгийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон", 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Албан томилолтын зардалтай давхардуулан олгосон хоол, унааны хөнгөлөлт 7,700,000.00 /Долоон сая долоон зуун мянган/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Төрбаяр/, ерөнхий нягтлан бодогч /Н.Наранцэцэг/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ц.ЭНХЖАРГАЛ
Ж.МӨНХБИЛГҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 18/АД170104

Улаанбаатар хот

САГ - 2026/98/ИА - СТА - ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд: Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2025 оны А/630 дугаар тушаалаар гадаад улс оронд 53 хоногийн хугацаанд суралцсан нэр бүхий 1 албан хаагчид Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2024 оны А/408 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-д заасны дагуу сар бүр дундаж цалингийн 70 хувьтай тэнцэх тэтгэмж олгогчид бүтэн ажилласнаар тооцож 3,477,731.26 /Гурван сая дөрвөн зуун далан долоон мянга долоон зуун гучин нэгэн төгрөг хорин зургаан мөнгө/ төгрөгийн тэтгэмж илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2024 оны А/408 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8.1.2-т Суралцах хугацаанд 8.1.2.а "Байгууллагын захиалгаар 1-3 сарын хугацаагаар үндсэн ажлаасаа чөлөөлөгдөн сургалтад хамрагдсан тохиолдолд суралцах хугацааны сар тутамд тухайн ажилтны сарын дундаж цалингийн 70 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг олгоно", Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2024 оны А/630 дугаар тушаалын 2-т "Гадаад сургалтад хамруулахтай холбогдон гарах зардлыг батлагдсан төсвийн дагуу гарган зарцуулах, суралцах хугацааны сар тутамд дундаж цалингийн 70 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгохыг тус тус Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст зөвшөөрсүгэй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон", 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон тэтгэмж 3,477,731.26 /Гурван сая дөрвөн зуун далан долоон мянга долоон зуун гучин нэгэн төгрөг хорин зургаан мөнгө/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Төрбаяр/, ерөнхий нягтлан бодогч /Н.Наранцэцэг/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ц.ЭНХЖАРГАЛ
Ж.МӨНХБИЛГҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 139/А017-0104

Улаанбаатар хот

САГ - 2026/98/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2025 оны А/271 дүгээр тушаалаар "2025 оны өөрийн орлого болон урсгал зардлын хөрөнгөөр хэрэгжих худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-г шинэчлэн батлахдаа тайлант онд хэрэгжих боломжгүй нийт 453,530,000.00 /Дөрвөн зуун тавин гурван сая таван зуун гучин мянган/ төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.

2. Нийт 630,000,000.00 /Зургаан зуун гучин сая/ төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны гишүүд Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх мэдэгдлийг бөглөөгүй, үнэлгээний хорооны гишүүдийн худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан эсэх нь тодорхойгүй, тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтыг хэлэлцэх, сонгон шалгаруулах тендер нээх, үнэлэх хуралдааны тэмдэглэлгүй, хуралдааны тэмдэглэл иж бүрэн бус, тэмдэглэлд дарга, гишүүд гарыг үсэг зурж баталгаажуулаагүй нь хуралдаанд ирц бүрэн оролцсон эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

3. Нийт 53,530,000.00 /Тавин гурван сая таван зуун гучин мянган/ төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалттай Сангийн яам тендер оролцогчдоос ирүүлсэн гомдлын дагуу 2 удаагийн тендер шалгаруулалтыг хянаж тендер үнэлэх ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, үнэлгээний хорооны шийдвэрийг үндэслэлгүй гэж үзэн хүчингүй болгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 50 дугаар зүйлийн 50.3-т "Үнэлгээний хорооны гишүүн худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан байна", 51 дүгээр зүйлийн 51.3-т "Үнэлгээний хороо нийт гишүүний дөрөвний гурваас багагүй тооны гишүүний ирцтэй хуралдсанаар хурлыг хүчинтэйд тооцно", 51.8-д "Үнэлгээний хорооны гишүүд хуралд биечлэн оролцсон эсэхээс үл хамааран зөвлөмжтэй танилцаж, түүнийг дэмжих эсэх саналаа тусган цахим системээр баталгаажуулах үүрэгтэй", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-т "төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх", Сангийн сайдын 2023 оны 250 дугаар тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.12-т "Батлагдсан төлөвлөгөөнд дараах тохиолдлоос өөр үндэслэлээр нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно:", 2.12.1-д "тухайн жилийн төсөвт тодотгол хийсэн, хуульд заасан бусад эх үүсвэр батлагдсан, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлд зааснаар төсөвт

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125.SAG-17.Docx

1526180358

зохицуулалт хийсэн”, 2.12.2-т “энэ журмын 1.7-д заасан захиалагчийн тухайн онд хэрэгжүүлэхээр батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол, хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагааг хэвийн явуулахад хүндрэл үүссэн” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн батлахдаа тайлант онд хэрэгжих боломжгүй шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг нэмж баталдаг, Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Төрбаяр/, ерөнхий нягтлан бодогч /Н.Наранцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР АУДИТЫН МЕНЕЖЕР АХЛАХ АУДИТОР АУДИТОР		Ц.НАРАНЧИМЭГ Д.ЭНХДАЛАЙ Ц.ЭНХЖАРГАЛ Ж.МӨНХБИЛГҮҮН
--	--	--



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 138/А0170104

Улаанбаатар хот

САГ - 2026/98/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Шилэн дансны мэдээллийн цахим хуудсанд байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан, Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг иж бүрэн байршуулаагүй;
2. Иргэний нисэхийн ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн дотоод аудит үр нөлөөгүй, хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.2-т "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор", 6.10-т "Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулаагүй, дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Төрбаяр/, ерөнхий нягтлан бодогч /Н.Наранцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ц.ЭНХЖАРГАЛ
Ж.МӨНХБИЛГҮҮН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-н хороо, Бага төбөрүү-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-261230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-17.Docx

1526:80356



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 137/АД170104

Улаанбаатар хот

САГ-2026/98/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Бэлэг дурсгалын зүйлс худалдан авахад 36,909,500.00 /Гучин зургаан сая есөн зуун есөн мянга таван зуун/ төгрөг;
2. Тэмцээн, уралдаан зохион байгуулахтай холбоотой 21,923,600.00 /Хорин нэгэн сая есөн зуун хорин гурван мянга зургаан зуун/ төгрөг;
3. Тээврийн хэрэгслийн дулаан зогсоолын түрээс 20,980,000.00 /Хорин сая есөн зуун наян мянган/ төгрөгийг тус тус зарцуулсан;
4. Тайлант онд орлогоор бүртгэсэн тээврийн хэрэгслийн улсын дугаар нь бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугааргүй;
5. Нэр бүхий 9 албан тушаалтан албан тушаалын суудлын автомашин ашиглаж байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно", 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ", 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон, хязгаарласан арга хэмжээ зохион байгуулсан, санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Төрбаяр/, ерөнхий нягтлан бодогч /Н.Наранцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ц.ЭНХЖАРГАЛ
Ж.МӨНХБИЛГҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 136/АД170104

Улаанбаатар хот

САГ - 2026 /98/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэгт хамааралгүй дараах чиглэлээр гадаад албан томилолтоор ажиллуулж, нийт 47,352,340.40 /Дөчин долоон сая гурван зуун тавин хоёр мянга гурван зуун дөчин төгрөг дөчин мөнгө/ төгрөгийн томилолтын зардлыг олгосон байна. Үүнд:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2025 оны А/123 дугаар тушаалаар "Тайландад Иргэний нисэхийн сургалтын төвтэй харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах" гадаад томилолтын зардал 9,480,345.20 /Есөн сая дөрвөн зуун наян мянга гурван зуун дөчин таван төгрөг хорин мөнгө/ төгрөг;
2. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2025 оны А/163 дугаар тушаалаар "БНХАУ-ын Шанхайн олон улсын сансрын технологи, тоног төхөөрөмжийн үзэсгэлэнд оролцох" гадаад томилолтын зардал 8,555,850.00 /Найман сая таван зуун тавин таван мянга найман зуун тавин/ төгрөг;
3. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2025 оны А/264 дүгээр тушаалаар "АНУ-ын Холбооны нисэхийн захиргаатай хийх уулзалт"-д оролцох гадаад томилолтын зардал 16,406,410.80 /Арван зургаан сая дөрвөн зуун зургаан мянга дөрвөн зуун арван төгрөг наян мөнгө/ төгрөг;
4. Тушаал шийдвэргүйгээр "Үндэсний болон олон улсын усан хилийн агаарын зайд хүнгүй нисэх төхөөрөмжийн системийг нэгтгэх" сэдэвт семинарт оролцох томилолтын зардал 12,909,734.40 /Арван хоёр сая есөн зуун есөн мянга долоон зуун гучин дөрвөн төгрөг дөчин мөнгө/ төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", ИНЕГ-ын даргын 2023 оны А/390 дүгээр тушаалаар баталсан "ХШҮДАА-ны даргын албан тушаалын тодорхойлолт"-ын албан тушаалын зорилго "Хууль тогтоомж, бодлого, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулахад, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахад болон хөрөнгө оруулалтын үр нөлөөг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, эрсдэлийн удирдлагаар хангах чиг үүргийн хүрээнд нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг даргын өмнө хариуцах", Албан тушаалын зорилт: 1. Хууль, тогтоомж, тогтоол, шийдвэр, дүрэм, журам, заавар, стандарт, бодлого, гэрээний биелэлтэд дотоод аудит, хяналт шалгалт хийж, байгууллагын үйл ажиллагааг дэмжих, эрсдэлийн

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-274230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-17.Docx

1526190352



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 135/АД170104

Улаанбаатар хот

САГ-2026/98/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Зам, тээврийн сайдын 2024 оны А/289 дүгээр тушаал, 2025 оны А/256 дугаар тушаал, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2024 оны А/631 дүгээр тушаалаар "ИНЕГ-ын орон тоо, ажлын байрны жагсаалт"-ыг тус тус батлахдаа дэд даргын орон тоог баталсан;

2. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2025 оны А/47 дугаар тушаалаар Ерөнхий менежерийн орон тоог нэмж бий болгож, мөн оны А/104 дүгээр "Цалин хөлсний сүлжээг шинэчлэн батлах тухай" тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газрын дэд дарга, ерөнхий менежерийн албан тушаалын цалингийн сүлжээг тус тус тусгаж баталсан;

3. Ерөнхий менежерийн орон тоонд 1 ажилтныг томилон ажиллуулж, 5-12 дугаар сарын хугацаанд нийт 62,617,598.32 /Жаран хоёр сая зургаан зуун арван долоон мянга таван зуун ерэн найман төгрөг гучин хоёр мөнгө/ төгрөгийн цалин хөлс олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Хуульд тусгайлан заагаагүй бол төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг Засгийн газрын агентлаг, Засгийн газрын ажлын алба, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага, эмнэлэг, төрийн болон орон нутгийн өмчийн их сургууль, төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компаниас бусад этгээд тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглоно", 5.4-т "Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилж, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно", Засгийн газрын 2025 оны 52 дугаар тогтоолын 4 дүгээр зүйл "Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн зохион байгуулалтын бүтцийг батлахдаа дараах чиглэлийг баримталж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай:", 4.1-д "хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын агентлаг нь дэд дарга, орлогч даргагүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-17.Docx

1526190350

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын тогтоолоор хориглосон орон тоо, албан тушаал бий болгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Төрбаяр/, ерөнхий нягтлан бодогч /Н.Наранцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ц.ЭНХЖАРГАЛ
Ж.МӨНХБИЛГҮҮН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 134/А0170104

Улаанбаатар хот

САГ-2026/98/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зам, тээврийн сайдын 2023 оны А/224 дүгээр "Зохион байгуулалтын бүтэц шинэчлэн батлах тухай" тушаал, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2023 оны А/253 дугаар "Орон тоо, ажлын байрны жагсаалт шинэчлэн батлах тухай" тушаалаар бүтцийн өөрчлөлтөөр дотоод аудитын албаны менежерийг орон тоо хасагдсанаас ажлаас чөлөөлж, Б/169 дүгээр тушаалаар 31,327,945.73 /Гучин нэгэн сая гурван зуун хорин долоон мянга есөн зуун дөчин таван төгрөг далан гурван мөнгө/ төгрөгийн тэтгэмжийг олгосон байна. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2025 оны Б/48 дугаар тушаалаар тус ажилтныг Иргэний нисэхийн бодлогын хэрэгжилтийн газрын менежер, Б/90 дүгээр тушаалаар Захиргаа удирдлага, хууль эрх зүйн газрын даргаар тус тус ажилд эргүүлэн томилсон байна.

